

Европын Нисэхийн Аюулгүй Ажиллагааны Агентлаг (EASA)-аас зохион байгуулсан тус агентлагийн хууль эрх зүйг сурталчлах ажлын уулзалтанд оролцсон НТЧХ-ийн дарга Н.Ганболд, ҮГХ-ийн дарга С.Ерөөлт нарын ажлын тайлан

EASA-н хууль эрх зүйг сурталчлах уулзалт нь 2009 оны 10 сарын 12-14 өдрүүдэд Бельги Улсын Брюссель хотноо зохион байгуулагдлаа. Уулзалтын үйл ажиллагаа нь 3 үндсэн хэсгээс бүрдсэн болно.

1. EASA өөрийн аюулгүй ажиллагааны эрх зүйн зохицуулалтын бичиг баримтыг танилцуулах
2. EASA-н дүрмүүдийг хэрхэн хүлээн зөвшөөрөх, мөрдөн ажиллах, хамтран ажиллах, EASA-н техникийн тусламж дэмжлэгийн талаар хэсэгчилсэн уулзалт, ярилцлага хийх
3. Хэсэгчилсэн уулзалтуудын үеэр яригдсан асуудлыг нэгтгэн цаашид ажил хэрэг болгох талаар нэгдсэн дүгнэлт гаргах

Уулзалтанд EASA-н дүрмийг хүлээн зөвшөөрөх сонирхол бүхий хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсууд болох Таджик, Гүрж, Киргиз, Украин, мөн Камбоджи зэрэг улсуудаас гадна EASA-н дүрмүүдийг мөрдөж эхэлсэн Гонконг, Турк, Коста Рика, Африк, Латин Америкийн бүсийн салбар байгууллагуудаас нийт 50 гаруй хүн оролцсон томоохон уулзалт боллоо.

EASA-н эрх зүйн орчин өнөөдрийн байдлаар Нислэгт тэнцэх чадварын дүрмүүдийг бүрэн хамарсан, үнэмлэхжүүлэлт, нислэгийн үйл ажиллагааны зохицуулалтын дүрмүүд батлагдан хэрэгжиж эхлэх шатандаа, нислэг хөдөлгөөн, аэродромын зохицуулалтын дүрмүүд боловсруулалтын шатандаа тус байгаа бөгөөд 2012 оны 4 сар гэхэд бүх салбар чиглэлийг бүрэн хамарсан цогц эрх зүйн зохицуулалт болох юм байна.

EASA-н дүрмийг хүлээн зөвшөөрч, мөрдөн ажиллаж байгаа Гонконг, Сейшелийн арлууд, Сингапур, Вьетнам зэрэг зарим улс орны жишээн дээрээс харахад тодорхой зарим дүрмийг шууд хүлээн зөвшөөрч хэрэгжүүлдэг, зарим дүрмийг үндэслэн өөрийн нөхцөлд тохируулсан өөрийн дүрмийг гаргаж мөрдөх, хүлээн зөвшөөрөх талаар хуульчилж өгсөн зэрэг зохицуулалтыг хийсэн байна.

Уулзалтанд оролцсон Монголын төлөөлөгчид Агаарын хөлгийн инженерингийн байгууллагын гэчилгээжилтийн тухай, EASA-н дүрмийг мөрдөж эхлэхэд гарч болох хүндрэлүүд болон эхний үе шатанд хүлээн зөвшөөрсөн дүрэм, журмыг хэрхэн сурталчилж байсан талаар асуултуудыг тавьсанаас гадна дараахи саналуудыг тавьсан болно.

1. EASA-аас өөрийн дүрэм журмуудыг хүлээн зөвшөөрч, мөрдөн ажиллах талаар мэдээллийн гарын авлага, бусад улсуудын хэрэгжүүлсэн туршлага, зохистой ажиллагааг үзүүлсэн баримт зайлшгүй хэвлэж танилцуулах шаардлагатай байгааг EASA хүлээн зөвшөөрсөн болно
2. Мөн Агаарын хөлгийн инженерингийн байгууллагын гэчилгээжилтийн шаардлага нь Европын холбооны улсад бүртгэлтэй агаарын хөлөг ашиглагч улсад үзүүлэх нөлөөллийг тодорхой болгох талаар албан ёсны тайлбар гаргаж өгөхийг хүссэн болно

Мөн EASA-н гадаад хамтын ажиллагааны менежер Эрик Фернандес, мэргэжилтэн Хуан Моралес нартай уулзаж Монгол Улсын иргэний нисэхийн өнөөгийн хөгжил, эрхзүйн орчин, EASA-ийн НТЧ-ын дүрмийг судлах шаардлагын талаар санал солилцож ярилцсан. Тэдний зүгээс Монгол Улс EASA-тай цаашид хэрхэн хамтран ажиллах, ямар төрлийн тусламж дэмжлэг хүсэх талаар саналаа албан ёсоор ирүүлэхийг хүссэн. Учир нь EASA ямар улсад ямар хэмжээний тусламж дэмлэг

үзүүлэхийг Европын Комиссын хэмжээнд оруулж шийдвэрлүүлдэг болох талаар мэдэгдэж байсан юм.

Уулзалтын үр дүнг үндэслэн дараах саналыг гаргаж байна.

1. EASA эрх зүйн орчин нь ИКАО-н стандарт шаардлагуудтай хэрхэн нийцэж байгаа талаар мэдээллийг хүсэлт гарган авах
2. EASA-н холбогдох зарим хүмүүсийг Монгол Улсад урьж цаашдын техникийн хамтын ажиллагааны талаар ярилцах
3. EASA-н зарим дүрмийг хүлээн зөвшөөрөх (21, 66, 145, 147, аннекс 16-г зохицуулсан дүрэм) урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өөрийн холбогдох дүрмүүдийг дээрхи дүрмүүдтэй харьцуулсан судалгааны ажлыг хийж дуусгах
4. EASA-н орчинд байцаагч нарыг сургах талаар хүсэлт тавих

МИАТ ХК-н техникийн газрыг EASA Part M, Subpart G-н дагуу гэрчилгээжүүлэх ажил явагдаж байгаатйа холбогдуулан энэ талаар бидний тавьсан асуултанд дэлгэрэнгүй хариулт өгөөгүй бөгөөд яг энэ чиглэлээр ирэх 11 сард зохиогдох “EASA-н Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжилтүүлэлт, Агаарын хөлгийн инженерингийн байгууллагын гэрчилгээжилт” сэдэвт семинарт оролцохыг санал болгож байгааг EASA-аас тэмдэглэн, албан ёсны урилга ирүүлэхээр тохиролцов.

Тайлан бичсэн

НТЧХ-ийн дарга Н.Ганболд

ҮГХ-ийн дарга С.Ерөөлт